



“ДОРНОД ХУДАЛДАА” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 03-ны өдөр
хот

Дугаар 2023/01

Чойбалсан

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60, 61, 65, 67 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. “Дорнод худалдаа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн Баасан гарагийн 15:00 цагт Дорнод аймгийн Хэрлэн сумын 6 дугаар багт байрлах Дорнод худалдаа ХК-ийн байранд зарлан хуралдуулсугай.

Хоёр. Ээлжит хурлын дэгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

Гурав. Хурлын нийтэд хүргэх зарыг загварыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

Дөрөв. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлыг “Санал авах хуудас”-ыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

Тав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

Зургаа. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрөөр тогтоосугай.

Долоо. Хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2023 оны 03 дугаар сарын 22-ний өдрийн 17:00 цагаар тогтоосугай.

Найм. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын дарга Д.Шинэбаяр, тооллогын комиссын дарга Д.Тунгалагтуул, гишүүд Л.Цэдэн, Ц.Содбаяр, хурал зохион байгуулах комиссын дарга Д.Шинэбаяр, гишүүд Л.Цэдэн, Б.Батцэцэг нарыг тус тус томилсугай.

Ес. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид энэхүү шийдвэрийн дөрөвдүгээр хавсралтад заасан бичиг баримтыг 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрөөс 03 дугаар сарын 22-ны өдөр хүртэл Даваа-Баасан гарагийн 09:00-17:00 цагт компанийн байранд нарийн бичгийн даргаас авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

Арав. Компанийн ээлжит хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцуулах эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээллэх, энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 03

дугаар сарын 21-ны өдөр дахин мэдээллэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

Арван нэг. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх, хурлын зар мэдээг Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоол "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай журам"-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэж ажиллахыг гүйцэтгэх захиралд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА *Ц.ШИНЭБАДАМ* Ц.ШИНЭБАДАМ

